



Улсын хилийн ажал, түүх

МОНГОЛ-ТУВАГИЙН ХООРОНД ХИЛ ТОГТООЖ БАЙСАН ТУХАЙ.

Нэг. Ардын хувьсгалаас өмнөх үеийн Монгол-Тувагийн хооронд
газар нутгийн асуудал шийдвэрлэж байсан тухай.

Одоогийн ОХУ-ын Автономит Тува улс нь 1921 оны 8 сард ардын хувьсгал ялж Бүгд Найрамдах Тува Ард Улсаа тунхагласан бөгөөд 1944 оны 8 дугаар сард ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд оржээ. Тува Улс нь эрт дээр үеэс манай монгол улстай хаяа нийлэн Тагна Урианхайн хязгаар гэж нэрлэгдсээр иржээ.

Манж улс Хаант Оростой 1727 онд байгуулсан хилийн гэрээ /Буурийн гэрээ/-гээр Тагна-Урианхайн баруун хойд талын Шавинайн даваанаас Эргүнз гол хүртэл байгуулж Монгол-Тагна-Урианхайн нутгийн хойд захыг Хаант Оросоос хязгаарлах улсын хилийг тогтоосон байна.

Тагна-Урианхай нар XVIII зууны үед урд талаараа Увс нуурын хойд хөвөө, Хан Хөхийн нуруу хүртэл нутаглан сууж байжээ.

Заг, Байдрагаар нутаглаж байсан Дөрвөдийн 2 аймаг, 16 хошуу нь Манжид дагаар орж Манжийн хаанаас 1770-аад онд нутаг гуйж Улаангомьн тариалан эрхлэх газар шилжин суурьшжээ.

Дөрвөдүүд Улаангомд шилжин суусан тэр үеэс Тагна-Урианхай нар Увс нуур, Ханхөхийгөөс хойд зүгт шахагдан нутаглаж байсан тухай академич Б.Ширэндэвийн редакторлаж Майский гэдэг хүний бичсэн "Хувьсгалын өмнөх монголын тухай" зохиолд дурдсан байдаг.

Монголын аймаг хошууд Манж, Хаант Оросын хооронд 1727 онд Хилийн гэрээ байгуулах үед өөр хоорондоо болон ялангуяа хойд талын Орос улстай зах нийлсэн газар нутгийнхаа хилийн овоо, тэмдэг, харуул хайчийн замыг тодорхойлсон дэвсгэр нутгийнхаа цэс үйлдэж, тодорхойлолт бичиг хийж өргөн, түүнийхээ дагуу тухайн үед зах нийлсэн нутгаа хамгаалж иржээ. Манж улс Халх монголыг эрхшээлдээ оруулсаны дараа Хаант Оросоос сэрэмжлэхдээ Монголын хойд хилээр 70-аад тооны харуулыг чандлан суулгасны дотроос 1804 онд /Сайшаалт Ерөөлтийн 8-р он/ Алтайн суман харуул байгуулахдаа Дөрвөд, Тагна-Урианхайн хооронд улсын чанартай хил тогтоогоогүй ч гэсэн Монгол-Тагна-Урианхай нарыг хооронд

нь заагласан нутгийн захаар Хатуу-Улиастай хэмээх газраас Жинжилиг хүртэл /Хатуу-Улиастай, Чигэрстэй, Өрөг нуур, Ботгон хоолой, Бор Ишгэнт, Хандгайт, Чацаргана, Орхигбулаг, Алаг-Овоо, Самгалтай, Эрсүүн, Жинжилиг/ 12 харуул суулгаж, харуул бүрт 30-40 цэрэг, уналгын агт морь, цалин пүнлүүг өгч байсан баримтаас үзэхэд Монгол улс Тагна-Урианхайтай зах нийлсэн нутгаа харуулаар хамгаалж иржээ.

Тагна-Урианхай нь хэдийгээр Манжийн нэг зах хязгаар нутаг боловч тэд өөрсдийнхөө дэвсгэр нутгийн цэсийг 1729 /Найралт төвийн 6-р он/ оны сүүл сард, 1875 /Бүрэн Засагчийн 8-р он/ оны 5 сар,, 1892 /Бадруулт Төрийн 17-р он/ оны 7 сар, 1910 /Хэвт ёсны 2-р он/ намар цагт шинэчлэн үйлдэж тодорхойлолт гаргаж байжээ.

Тагна-Урианхайн гаргасан эдгээр дэвсгэр нутгийн цэсээр бол дэвсгэр нутгаа тойруулан 38 хилийн хайчийн овоо босгосноос 25 нь монголтой залгаа нутагт байжээ.

Дээрх түүхийн хилийг Монголын Ховдын хязгаарын нутгийн 1890, Дөрвөд аймгийн нутгийн 1908, Тагна-Урианхайн нутгийн 1910 онуудын нутгийн цэс гаргасан зураг дээр үндэслэх болж байна.

Эдгээр зургаар бол Тагна-Урианхай нь баруун талаараа Шавийн дархадтай, Засагт хаан аймгийн хойд зах Бэлдэс, Цагаанбулан, Агар, Шавар, Баянбулаг, Жинжилиг харуулуудын хамгаалах хэсгээр хиллэж байжээ.

Тагна-Урианхайн урд хэсэг Увс нуураас зүүн тийш, Тэс голын хойд тал Алаг-Овоо, Самгалтай, Эрсүүн, Жинжилиг харуулын хайчийн зам, овооноос хойгуур нутаглаж байсан Тагна-Урианхайн занги Мэнеэ гэгчийн нэг сумын ард олны хүсэлтээр 1777 онд /Тэнгэрийг тэтгэсний 41-р он/ дээрх харуулаас урагш Алтайн элсний өмнө хэсгээр нутаглахыг Манжийн Улиастай дахь цэргийн хүрээнээс зөвшөөрч тэрхүү нутгийг түр эзэмшүүлжээ. Мөн 1824 онд /Төр гэрэлтийн 4-р он/ Тагна-Урианхайн Соёуд сумын ардууд Алтан элснээс зүүн урагш Хангилцаг, Цагаан-Усны голын хоорондох тууш нутгийг урд тал нь Хан Хөхийн уулын ар хормой хүртэл дахин сунгаж эзэмшүүлжээ.

Тагна-Урианхайн ардууд түр эзэмшихээр хоёр дахин гуйж авсан нутгийнхаа захаар овоо тэмдэг босгож зэргэлдээ халх дөрвөдийн хошуунаас заагласан нь тэрхүү нутгаа бүрмөсөн эзэгнэх ёстой мэт үзэж байжээ. Энэ байдал 1910 онд /Хэвт ёсны 2-р он/ үйлдсэн гадаад орос, жич олон харуул, дархад, дөрвөд, халх хошуудтай зах хязгаар нийлсэн Тагна-Урианхайн нутгийн зургаас харагдаж байна.

Суман, харуулуудаас хилийн овоо тэмдгээ шалгадаг хайчийн зам, харуулын нэрсийг тусгаснаас үзэхэд Тагна-Урианхайн нар дурдсан нутгийг

түр эзэмшүүлэхээс өмнө тэдний нутгийн зааг хаагуур байсныг энэхүү зураг дээр нотолж байна.

Тагна-Урианхай нар түр эзэмшиж байсан нутгийхаа өмнөд захыг Хан Хөхий уулын ар хормойгоор хязгаарлаж зураг дээр харуулжээ.

Халхын Засагт хан аймгийн 19 засаг хошууны нутгийн зургийг 1908 оны /Бадруулт төрийн 33-р он/ 12 сард үйлдэхдээ Бэлдэс харуулаас Цагаантолгой хүртэл харуулаар Тагна-Урианхайтай зах нийлж байгаагаар харуулаад Хангилцаг гол, Цагаан-усны голын хоорондох Тэс голоос урагш Хан Хөхий хүртэл хэсэг нутагт Тагна-Урианхайтай хамт нутаглана гэж заажээ. Мөн 1891 онд /Бадаргуулалт төрийн 16-р он/ Дөрвөдийн 2 аймгийн нутгийн цэс, Хатуу-Улиастайн харуулаас зүүн тийш Чигэрстэй, Өрөгнуур, Ботгон хоолой, Бор-Ишгэнт, Хандгайт, Чацаргана, Орхигбулаг, Алаг-Овоо, Самгалтайн харуулуудын пайзат овоонуудаар Тагна-Урианхай, Дөрвөд, Халхын Засагт хан аймгийн нутгийн цэсэд заасан хязгаар нь Тагна-Урианхайн нутгийн зах хязгаарын нэрстэй тохирч байаа учир одоогийн Монгол Улс, ОХУ-ын БН Тыва улсын хоорондын улсын хилийн түүхэн шугам энэ заагаар байсан гэх үндэстэй байна. 1921 онд Монгол болон Тагна-Урианхайд ардын хувьсгал ялж тусгаар тогтносон улс болоход хил дээр сууж байсан харуулуудыг буулгажээ. Хилийн харуулуудыг буулгаж хил хязгаарыг цагдан хамгаалах эзэнгүй болсныг далимдуулан Тагна-Урианхайн ардууд монголын нутаг руу түрж эзэмших явдал эхэлсэн тэр цагаас газар нутгийн маргаан үүсэж хоёр улсын хооронд албан ёсны хил тогтоох шаардлага гарсан байна.

Хоёр. Монгол-Тувагийн 1930 оны хилийн хэлэлцээ, үр дүн.

Монгол-Тувагийн хооронд найрамдлын холбоо байгуулах тухай Засгийн Газрын 1926 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатарт байгуулсан Гэрээний 6-р зүйлд хоёр улсын хилийг албан ёсоор тогтоохоор комисс байгуулж ажиллахыг заажээ.

БНМАУ-ын Засгийн Газрын 1930 оны 6 дугаар хурлын тогтоолын II зүйлд Туватай зах нийлсэн хязгаарыг ялган салгаж тогтоох комисс байгуулж, даргаар нь Ламжав, гишүүдээр Чандмань аймгийн дарга Эрдэнэ, цэргийн яамны түшмэл Магсаржав, Гадаад яамны Баянчуулган, Чандмань уулын аймгийн дарга Дашзэвгэ, Гадаад яамны Цогтцэмбэл нарыг баталжээ.

Тэд Тувагаас томилогдсон Данж тэргүүтэй хүмүүстэй 1930 оны 10 дугаар сарын 11-нд Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Харгийн гол дээр уулзаж үүрэгт ажилдаа оржээ.

1930 оны 3 дугаар сарын 16 нд "Монгол, Тувагийн Намын Төв хороодын дарга Элдэв-Очир, Бадрах, Тока нар хил тогтоох асуудлыг

хэлэлцэн тохирсоны ёсоор тогтоол гаргаж тэр дагуу манай талын комисс тусгай удирдамжтай ажилласан байна.

Тувагийн тал өнгөрсөн зууны үеэс нутаг түрэн хуучин хайчийн замаас урагш орж барилга байшин барьж, тариа тарьж байснаа баримталж Хан Хөхийн нурууны ар ёроолоор хил тогтоох гэж мэтгэлзэж байсан байна.

Комиссын монголын талын төлөөлөгчид хуучин хилийн овоо, хайчийн замыг баримтлахыг аль болохоор хичээж байжээ. Хил тогтоох комисс 1930 оны 10 дугаар сарын 11-нээс мөн оны 11 сарын 18-ныг хүртэл хилийн баруун үзүүрийн Улаанбайшинтаас /Зөөлөн хөндийгөөс / зүүн тийш Цагаантолгой хүртэлх газрыг нүдээр үзэж хэлэлцээ явуулсан боловч Хан хөхий хүртэлх нутгийн талаар санал зөрөлдөж маргалдан энэ хэсэгт хоёр талын саналыг ойртуулж чадсангүй, хэлэлцээ засварласан байна. Харин Цагаантолгойн зүүн талын Жинжилиг харуулаас зүүн тийш газрыг дараа жилийн 1931 оны хавар ажиллах комисс шийдэх ёстой гэж ярилцаад баримт бичигт гарын үсэг зурсан байна.

Гурав. Монгол-Тувагийн 1932 оны хилийн хэлэлцээ, үр дүн

БНМАУ-ын Засгийн Газрын эрхлэх товчооны 1932 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 9 дүгээр хурлын тогтоолын 4 дүгээр зүйлд Монгол, Тувагийн нутгийн хилийн хэргийг цэгцлэн гүйцэтгэх комисст нөхөр Ламжав, Цэенрэгзэн, Дөрвөд аймгийн дарга Санжмятав, орчуулагч Мишкиров нарыг томилсон тухай дурджээ. Харин комиссын ажил эхлээд Ламжав өвчтэй байсан учир комиссын даргаар Цэенрэгзэнг томилж, гишүүнээр Тува улсад суугаа Бүрэн Эрхт Төлөөлөгч Дугаржавыг оруулжээ.

Уг комисс "Монгол, Тагна-Тува улсын хил тогтоох тухай 1930 оны 3 дугаар сарын 16-ны өдөр хуралдсан хоёр улсын Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний шийдвэр болон 1930 оны комиссын баримталсан зарчмын чиглэл"-ийг удирдамж болгон ажиллажээ.

Монгол Ард Засгийн Газраас энэ комиссын монголын хэсгийн төлөөлөгчдөд 1932 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр үнэмлэх шийтгэн олгосноор 1932 оны 5 дугаар сарын эхээр комисс ажилдаа орсон бололтой.

Хилийг тогтоох комиссын хоёр талын төлөөлөгчид хамтран хилийн баруун талын цэгээс эхлэн саналаа нэгтгэн явж, санал зөрөөтэй газрын асуудлыг 1932 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Дөрвөд аймгийн Зүүнхангай сумын нутаг Хүйс хэмээх газар хуралдсан 1 дүгээр хуралдаанаар хэлэлцжээ. Уг хуралдааны Тогтоолд:

1. Давст уул болбоос Тагна-Тува ард улсын давсны асуудлыг хангах ганц газар болох тул Тагна-Тува ард улсын дэвсгэр нутагт оруулав. . .

3. Увс нуурын зүүн өмнө этгээдэд буй зөрөлдөөн бүхий дөрвөлжин хэсэг газрыг хойд ба өмнө хоёр тэгш болгон хувааж, хилийг Ахар уулын өврөөр Элсийг дайруулан Нисэх уулын орой хүртэл татаж хойд талыг Тагнад, өмнө талыг Монгол улсад оруулав. . .

6. Энэ тогтоолыг хоёр улсын Засгийн Газраас батласны дараа хуулийн хүчин бүхий болно" гэжээ.

1932 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 2-р хурлын Тогтоолд:

"Хилийг Зөөлөн хөндийгөөс эхлэн Асгатын давааны оройгоор Ногоон нуур, Асгатын голоос зүүн тийш явах газрын нэрийг дараалан зааж, Давс уулын баруун өмнүүр ёроол талаар тойрон гарч, Хурган Шивэр гол чиглэж . . ." гээд Ахарын сарт толгой дээгүүр Элсээр дайран Бэрх толгой хүртлэх Увс аймгийн хойд хилийн шугамыг заагаад энэхүү тогтоолыг хоёр улсын Засгийн Газар хянуулан батлуулах болно" гэжээ.

1932 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 2 дугаар хурлын Тогтоолд:

"Хилийг Зөөлөн хөндийгөөс эхлэн Асгатын давааны оройгоор Ногоон нуур, Асгатын голоор зүүн тийш явах газрын нэрийг дараалан зааж, Давс уулын баруун өмнүүр ёроол талаар тойрон гарч Хурган Шивэр гол чиглэж . . ." гээд Ахарын сарт толгой дээгүүр Элсээр дайран Бэрх толгой хүртлэх Увс аймгийн хойд хилийн шугамыг заагаад энэхүү тогтоолыг хоёр улсын Засгийн газар хянуулан батлуулах болно" гэжээ.

1932 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 3 дугаар хурлын Тогтоолд:

1. . . Монгол ба Тувагийн ардуудад аль улсын харьяат болохыг өөрсдийн саналаар гүйцэтгүүлнэ.

Энэ тогтоолыг хоёр улсын Засгийн Газраас 1933 оны 5 дугаар сарын 1-нээс өнгөрүүлэхгүйгээр батласны дараа нүүдэллэнэ" гээд "Энэ тогтоолыг хоёр улсын Засгийн Газраас батласны дараа хүчинтэй болно" гэжээ.

1932 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 4 дүгээр хурлын Тогтоолд:

"Хоёр улсын хил хязгаар орчимд суугаа ардууд ус, мод, түлш, газар эдэлбэрийн талаар Тувагийн талаас тавьсан саналыг . . . тусгай гэрээ бичгийн ёсоор гүйцэтгүүлэх болно" гэжээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1932 оны 8 дугаар хурлын тогтоолын 1 дүгээр зүйлд комиссын дарга Цэенрэгзэнгээс хил хязгаарыг тогтоосон тогтоолын илтгэлийг сонсоод " . . . Хил хязгаарын нутгийн зөрөлдөөн бүхий асуудлыг таслан шийдвэрлэсэн 1, 2, 3 дугаар хурлын тогтоол нь үндсэндээ зүйтэй болсон тул ёсоор болгон батлахаас гадна энэ комисс нь газрын зөрөлдөөнийг шийдвэрлэхээс бус нутаг дэвсгэрийг эдлэх тухай хэлэлцэх явдалгүй" гэж үзээд 4 дүгээр тогтоолыг хэрэгсэхгүй болгожээ.

Мөн Тува Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1932 оны 12 дугаар сарын 22-ны 81 дүгээр хурлын тогтоолын 9 дүгээр зүйлд хилийн шугамыг

тогтоох комиссын дарга Токагийн илтгэлийг сонсоод "Хоёр комиссын нийлэн хуралдаж гаргасан дөрвөн /1, 2, 3, 4 дүгээр тогтоол/ зүйлийн тогтоол нь зөв. . ." гэж үзжээ.

Гэвч Увс аймаг, Тувагийн хоорондох хилийн шугамыг хоёр комиссоос нэрлэн зааж баталсан боловч овоо тэмдэг босгож тэмдэглэх ажил хойшлогдож байсныг манай улсаас Тувад сууж байсан төлөөлөгч Догсомоос 1934 оны 1 дүгээр сарын 23-ны 1 тоотор өөрийн ГЯЯ-нд бичихдээ "... хилийн овоо тэмдэг байгуулах явдлыг энэ 1934 оны 5 сард гүйцэтгэхээр хэлэлцвээс ямар бол гэх боловч зохих газрын зааврыг хүсэх тул. . ." гэснийг үзэхэд хилийг газар дээр нь тэмдэглэх ажил удааширсан нь харагдаж байна.

Харин Завхан, Хөвсгөл аймгийн хойд хилийг Цагаантолгой хэмээх газраас эхлэн Мөнхсарьдаг хүртэлх газрыг хуучин овоо, тэмдгийг баримталж тогтоохоор үндсэндээ зөвшөөрөлцөж 1934 оны 8 дугаар сарын 28-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч бөгөөд Сангийн Яамны сайд Довчин, БНТАУ-ын Ерөнхий сайд Жүрмэддаш нарын хэлэлцээрээр шийдсэн боловч газар дээр нь мөн л тогтоон тэмдэглээгүй байна.

Дөрөв. Монгол-Тувагийн 1940 оны хилийн хэлэлцээ, үр дүн

1940 оны 5 дугаар сарын 21-ний өдөр маршал Х.Чойбалсан Тувагийн элчин Намсрай нар харилцан хэлэлцээ явуулж хоёр улсын хилийг тодотгон тогтоох хэлэлцээ явуулах зарчмыг 1 дүгээрт хуучин түүхийн хилийг баримтлах, 2 дугаарт 1932 оны хэлэлцээг яг баримтлахгүй харгалзан үзэх, 3 дугаарт хил орчмын ард олны идээшил суурьшлыг харгалзан зохицуулахаар тогтжээ.

БНМАУ-ын Засгийн Газрын комисс /дарга нь С.Янжмаа, гишүүдэд Шаравсамбуу, Осор/, БНТАУ-ын Засгийн Газрын комисс /дарга нь Бидэр, гишүүд нь Цэдэв, Даваажав/ БНМАУ, БНТАУ-ын улсын хилийг тодотгон тогтоох асуудлаар 1940 оны 8 дугаар сарын 12-ноос хойш 7 удаа хамтран хуралдаж 1940 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар хуралдаанаараа ажлынхаа дүнг хэлэлцээд гаргасан тогтоолд:

Хоёр улсын Засгийн Газрын комисс улсын хилийн тухай түүхийн хуучин материалыг үндэслэн, хоёр улсын хилийн орчим суугаа ардуудын ашиг тусыг харгалзан, тус тусын хувьсгалт улс төрийн бодлого, найрамдалт харилцаанд тохируулан хоёр улсын хилийн шугамыг тодотгон тогтоох асуудлыг харилцан хэлэлцсэнийг тэмдэглэжээ.

Тувагийн комисс нь өөрийн улсын хилийг Увс нуурын хойд хөвөөгөөр байх ёстой гэсэн боловч чухам хэдийд тийнхүү хиллэж байсныг гэрчлэх баримт материал олдоогүйг дурдаад тогтоосон нь:

1. Улсын хилийн шугамыг:

- Зөөлөн хөндийгөөс Ногоон нуур хүртэл хуучин хилээр нь,
- Ногоон нуураас Асгатын голыг уруудан Асгат, Бөхмөрөн голын бэлчирээс 4 км дутуу газраас зүүн тийш эргэж Сэвстэй уулын үзүүр оройгоор Тувагийн Хар уулын өвөрт хилийн замд нийлүүлэх,
- Гурван Турагаас Гурван Солжирын орой хүртэл хэсэгт хоёр талын комиссын санал нийлжээ,
- Хоёр улсын комиссууд дээр дурдсанаас бусад хилийн ихэнх хэсгийг тодотгон тогтоох асуудлыг тохиролцож чадаагүй учир өөр өөрийн Засгийн Газар оруулахаар болжээ.

2. Монголын тал 1890 оны буюу Бадаргуулт төрийн 16 дугаар оны 10 дугаар сарын 9-ний өдөр үйлдсэн Дөрвөд аймгийн газрын зураг, 1907 он буюу Бадаргуулт төрийн 33 дугаар оны 9 дүгээр сарын 10-ны өдөр үйлдсэн нутгийн цэс, мөн Монгол-Тувагийн хил дээр сууж, харуул хайчийн үүрэг гүйцэтгэж байсан 12 харуулын байрлал, тэдгээрийн пайз овоонуудыг улсын хилийн шугам явж өнгөрөх үндэслэл болгосныг саналдаа тусгажээ.

3. Монгол-Тувагийн хилийг тодотгон тогтоох хэлэлцээний үеэр Тувагийн тал түүхийн хуучин баримт материалыг үл ойшоон, БНМАУ-ын нутаг дэвсгэрээс ихээхэн хэмжээний газрыг авах, хилийн шугамыг манай улсын нутаг дэвсгэр дээгүүр татахаар ямар ч үндэслэлгүй шаардлага тулгасныг манай тал зөвшөөрөх аргагүй байсан учир хилийн комисс өмнөө тавьсан зорилтыг шийдвэрлэж чадаагүй байна.

Энэ тухай ерөнхий сайд Х.Чойбалсан нь 1940 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 622 тоот бичгээр Москвад суугаа элчин Ж.Самбууд үүрэг өгөхдөө: Хоёр тал тохиролцож чадаагүйгээс гурав дахь этгээдийг оролцуулах тухай дурдаад ЗХУ-ын ГЯЯ-нд асуудал тавин тухайн хариу ирүүлэхийг даалгажээ. Элчин Ж.Самбуу нь 1940 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1407 тоот бичгээр ЗХУ-ын ГЯЯ-ны сайд Литвиновт хандаж комиссын илтгэл болон бусад 5 баримт бичгүүдийг явуулаад халуун зөвлөгөө өгч уг ажлыг түргэвчлэн шийдвэрлүүлэхийг хүсчээ.

Тав. Монгол-Зөвлөлтийн хилийг Тувагийн хэсэгт шийдвэрлэсэн тухай

Монгол-Зөвлөлтийн хилийг Тувагийн хэсэгт газар дээр нь тогтоож гэрээ байгуулахаар манай Засгийн Газар 1957 онд Зөвлөлтийн талд санал болгосны дагуу мөн оны 12 дугаар сараас 1958 оны 1 дүгээр сарын 30-ныг хүртэл Улаанбаатар хотноо хоёр талын төлөөлөгчдийн хооронд хилийн гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ явагдаж нийт 13 удаагийн хуралдаан болжээ.

Монгол-Зөвлөлтийн хоорондох Тувагийн хэсгийн 1305 км/ хилийн тухай Гэрээнд 1958 оны 3 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотноо БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1 дүгээр орлогч дарга Л.Цэнд, ЗСБНХУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд В.М.Молотов нар гарын үсэг зурав.

Уул гэрээг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1958 оны 4 дүгээр сарын 18-нд, ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчид 1958 оны 5 дугаар сарын 24-нд тус тус баталж, батламж жуух бичгүүдийг мөн оны 6 дугаар сарын 28-нд Москва хотноо солилцжээ.

Гэрээний дагуу хоёр улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажил 1959-1960 онд явагдаж дууссан бөгөөд демаркацийн баримт бичгүүдийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1961 оны 1 дүгээр сарын 16-нд баталжээ.

Ийнхүү Монгол, Тувагийн хооронд олон жил шийдэгдээгүй явж ирсэн хилийн асуудал нэг тийш болон шийдвэрлэгджээ.

Гэвч Ардын хувьсгалаас хойш 1979 оныг хүртэл Туватай залгаа хилд хилийн харуул байгаагүй учир хилийн элдэв зөрчил таслан зогсоогдоогүй байна. 1980 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр БНМАУ-ын Засгийн Газар, ЗСБНХУ-ын Засгийн Газрын хооронд байгуулсан "Хилийн дэглэмийн гэрээ" байгуулагдсанаар Увсын хэсэгт хилийн төлөөлөгчийн аппаратыг 1979 оны сүүлээр байгуулж эхэлсэн бөгөөд 1979-1984 оны хугацаанд Увс аймгийн нутагт Бөхмөрөн, Сагил, Боршоо, Давст, Тэс, Тохой, Харцагаан-усны постыг байгуулж хилийн дэглэм журам сахиулах болжээ.

Ахлах багш, дэд хурандаа Д.Шаравшагдар

Улсын хил хамгаалах, шийдвэр боловсруулахад математик загварчлал ба математик тооцоолох аргуудыг хэрэглэх нь

Энэ оны дөрөвдүгээр сард Улаанбаатар хотноо болсон манай улсын их, дээд сургуулиудын багш нарын эрдэм шинжилгээний бага хуралд Хилийн Цэргийн Сургуулийн Хил хамгаалалтын тэнхимийн багш, магистр Ц.Ганболдын илтгэл шалгарч тусгай шагнал хүртсэн юм. Бид сэтгүүлийнхээ энэ дугаарт дээрх илтгэлийг зохиогчийн зөвшөөрлөөр товчлон нийтэлж байна.